# Лицензийн шалгалтад бүртгүүлэх, шалгалт өгөх заавар

Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн систем

## Системд нэвтрэхдээ

http://hr.hdc.gov.mn/ линкээр нэвтэрнэ.

Нэг удаагийн код, банкны эрх, тоон гарын үсгээр нэвтрэхэд гар утсанд мессежээр ирсэн баталгаажуулах кодыг ашиглах тул гар утсаа ойр байлгана уу

## Үндсэн алхмууд

**1. Системд нэвтрэх**

Регистрийн дугаар, банкны эрх, тоон гарын үсэг аль нэгээр нэвтэрнэ.

**2. Шалгалтад бүртгүүлэх**

Лиценз цэсний лицензийн шалгалт дэд цэсрүү орж идэвхитэй байгаа шалгалтуудаас сонгон өгнө.

**3. Шалгалт өгөх**

Миний шалгалтууд цэсрүү орж шалгалтын хугацаа эхлэнгүүт шалгалтаа өгнө




## Холбоо барих

70128806

info@hdc.gov.mn

ЭМХТ 208 тоот

# Алхам 1. Системд нэвтрэх

Бүртгэлтэй болон шинэ хэрэглэгчдэд зориулсан заавар

## Дан системд бүртгэлтэй хэрэглэгч бол шууд нэвтэрнэ







## Чухал мэдээлэл

**Системд нэвтрэн орсны дараа бусад цэс харагдахгүй байвал боловсролын хүсэлт илгээх цэсний нэмэх товчыг дарж төгссөн сургуулийн дипломын зураг мэдээллээ оруулна. Бичиг баримтын хяналт хийгдсэний дараа та шалгалтад бүртгүүлэх боломжтой болно.**

# Алхам 2 : Шалгалтад бүртгүүлэх

Зарлал харах, бүртгүүлэх, төлбөр төлөх процесс




1. Лиценз цэсний лицензийн шалгалт дэд цэсрүү орж шалгалтын төрлөө сонгон идэвхитэй байгаа шалгалтуудаас сонгоно.
2. Бүртгүүлэх товч дарж шалгалт өгөх боломжит өдөр цагаа сонгон төлбөрөө төлж бүртгүүлнэ.
3. Миний шалгалтууд цэсрүү шилжин бүртгүүлсэн шалгалтаа өгнө.

### Чухал мэдээлэл

Банкны QR-аар шалгалтын төлбөрөө төлнө. Шалгалтын төлбөр буцаагдах боломжгүйг анхаарна уу.

# Алхам 3. Шалгалт өгөх



## Шалгалтын жагсаалт

Нийт: 1,540

Бүгд | **Зөвшөөрлийн** | Үндсэн мэргэшлийн | Төрөлжсөн мэргэшлийн | Дээшлүүлэх | Мэдлэг шалгах

Бүгд | Ажиллагсад | Төгсөгчид

| # | Шалгалтын нэр | Шалгалтыг үүсгэсэн | Бүртгээгүй | Бүртгэсэн | Буцаасан | Шалгуулагчийн төрөл | Бүртгэл эхлэх | Бүртгэл дуусах |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ажиллагсдын зөвшөөрлийн шалгалт | Э.Батжаргал | 0 | 753 | 45 | Зөвшөөрлийн шалгалт - Ажиллагсад | 2026-05-25 16:00 | 2026-05-30 18:00 |
| 2 | ГЭМ-1 | т.бат-эрдэнэ | 0 | 1 | 0 | Зөвшөөрлийн шалгалт - Ажиллагсад | 2026-03-26 15:11 | 2026-03-26 15:45 |
| 3 | ГЭМ 4 Мэргэжилтэн | т.бат-эрдэнэ | 0 | 4 | 0 | Зөвшөөрлийн шалгалт - Ажиллагсад | 2026-03-26 15:07 | 2026-03-26 15:30 |
| 4 | ГЭМ Шалгалт 2026.03.13 | т.бат-эрдэнэ | 0 | 1 | 0 | Зөвшөөрлийн шалгалт - Ажиллагсад | 2026-03-13 13:30 | 2026-03-13 14:10 |
| 5 | ГЭМ 2026.03.06 | З.Наранбаатар | 0 | 2 | 0 | Зөвшөөрлийн шалгалт - Ажиллагсад | 2026-03-06 13:55 | 2026-03-06 14:30 |

### Чухал мэдээлэл

-Шалгалтын төлбөр төлсний дараа шалгалт өгөх боломжтой.

-Шалгалтын цаг болонгууд шалгалт эхлэх товч идэвхтэй .

-Шалгалт өгч дууссаны дараа  10 минутын турш зөв хариултуудыг харах боломжтой.

# Лиценз хүлээн авах

Шалгалтаа амжилттай өгсний дараах мэдээлэл

## Амжилттай!

*Та лицензийн шалгалтаа амжилттай өгч таны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгагдлаа.*

## Лицензийн мэдээлэл

Лицензийн дугаар

**LICENSE-2024-001234**

Хүчинтэй хугацаа

**2026.07.01 - 2031.07.01**

**Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл** (лиценз) салбарын сайдын тушаалаар баталгаажна.

**Цахим лиценз системээс хэвлэн авах боломжтой**

## Холбоо барих

### Тусламжийн мэдээлэл

11461529

info@hdc.gov.mn

**Анхааруулга:** Лицензийн хүсэлтийг хүлээн аваад, сайдын тушаал гарсны дараа "Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв"-өөс сайдын тушаалын дугаарыг оруулснаар та Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй /лиценз/ болох юм. Үүнд тодорхой хэмжээний хугацаа шаардлагатай тул та бүхэн системийн зар хэсгээс мэдээлэл авна уу.

**70128806**

Холбоо барих утас

**info@hdc.gov.mn**

И-мэйл хаяг